

ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ХАН ТУУЛ ТӨВИЙН 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2025 он	Зорилтот түвшин	Хэрэгжилт ийн хувь	Хэрэгжилт
1.1	Тусламж үйлчилгээний чанарын магадлан итгэмжлэлийн хугацааг сунгуулах үйл ажиллагааны бэлтгэл хангах	Бэлтгэл ажлын хэрэгжилтийн хувь, Магадлан итгэмжлэлийн шинжээчийн үнэлгээ хийгдсэн байна	-	Хугацаа сунгагдсан байна	100%	Тусламж үйлчилгээний чанарын магадлан итгэмжлэлийн хугацааг сунгуулахаар үйл ажиллагааны 2026 оны 04 сараас эхэлж бэлтгэл ажлуудыг бэлдэж хийгдсэн. 04 сарын 10-нд ЭМХТөв лүү хүсэлтээ илгээж , магадлан итгэмжлэхийн өөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайланг ба холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, магадлан итгэмжлэхийн шалгуур үзүүлэлтийн дагуу заалтуудыг бичсэн бөгөөд 04 сарын 21-нд байгууллагын өөрийн үнэлгээ тайлан болон хүсэлтээ ЭМХТөв лүү илгээв. 05 сарын 27нд Тусламж үйлчилгээний чанарын Магадлан итгэмжлүүлэхээр ЭМЖТөвөөс 3 шинжээч томилогдон ирж өөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу шалгасан ба одоогоор өөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу шалгасан дүн гараагүй байна .
1.2	“Хүн төв”-тэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг бий болгох загварчлалын сургалтад хамрагдаж хэрэгжилтийг хангаж ажиллах	Сургалтад хамрагдсан ажилтны тоо	-	2	100%	НЭМГ-ын даргын 2026 оны А/32 тушаалын дагуу Эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх, анхан шатны тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг сайжруулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Их сургуулиас зохион байгуулагдах “Нийслэлийн хүн амд хүргэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн-төвтэй нэгдмэл загвар руу шилжүүлэх” арга зүйн сургалтад Төвийн хүний нөөцийн менежер Э.Бөртгөлжин 2026.03.03-2026.04.02 -ны хооронд хамрагдан суралцсан болно.

2.1	Эрүүл мэндийн даатгалын сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангах	Бэлтгэл ажлын хэрэгжилтийн хувь	-	Шалгуур үзүүлэлт хангах	50%	Эрүүл мэндийн даатгалын сонгон шалгуурлалтанд бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна
2.2	Холбогдох дээд газрын тушаалын дагуу томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед ор зохицуулалтын хуваарийн дагуу ажиллах	Томуу томуу төст өвчний үеийн хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн тоо	161	-	100%	Холбогдох дээд шатны байгууллагын тушаал, шийдвэрийн дагуу томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед ор зохицуулалтын хуваарийн дагуу ажиллах бэлтгэл ажлыг зохион байгуулж, эмнэлгийн орны нөөц, хүний нөөц, эм эмнэлгийн хэрэгсэлийн нөөц, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.
2.3	Сэргээн засах эмчилгээний эмнэлзүйн шинэ заавар боловсруулан, эмнэл зүйн зааврын тоог нэмэгдүүлнэ	Эмнэлзүйн зааврын хэрэгжилтийн хувь	80%	85%	100%	Сэргээн засах эмчилгээний эмнэлзүйн шинэ заавар боловсруулж байна
2.4	Амбулаториор үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Амбулаторын тусламж үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	3639	3650	45%	2026 оны I-II дугаар улиралын (1-5 дугаар сарын хугацаанд) байдлаар 742 хүүхэд амбулаториор үзүүлсэн ба үүнээс: Хэвтэн эмчлүүлэх шаардлагатай- 209 Өдрийн эмчилгээнд-201 Эрт илрүүлэг-332
2.5	Хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	Хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн тоо	1352	1400	40%	2026 оны I-II дугаар улиралын (1-5 дугаар сарын хугацаанд) байдлаар 209 хүүхэд Хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ авсан байна. Үүнээс: Хэл ярианы бэрхшээлтэй-37 Хэл ярианы илэрхий эмгэг -11 Саажилттай- 23 Аутизм-47 Хөгжлийн хоцрогдол-91
2.6	Эмийн эмчилгээний зохицуулах түр хороог байгуулж үйл ажиллагааг жигдрүүлэх	ЭЭЗХ хороог байгуулагдсан байна	-	1	100%	Төвийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/03 дугаар тушаалаар Эмийн эмчилгээг зохицуулах хороог 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна. 2026 онд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хорооны хурлыг 2 удаа зохион байгуулан, хэлэлцэх асуудлуудыг шийдвэрлэн ажиллалаа.

2.7	Тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, эмчилгээний шинэ арга, техник технологи нэвтрүүлэх	Шинээр нэвтрүүлсэн тусламж үйлчилгээний тоо	4	6	100%	Хүүхдийн мэдрэхүйг сайжруулах, тайвшруулах, анхаарал төвлөрөлтийг дэмжих зорилгоор Мэдрэхүйн гэрэл өрөөг тусламж үйлчилгээнд нэвтрүүлэхээр өрөөг I-II дугаар улиралд тохижуулан ажилласан.. 2026 оны III дугаар улиралд үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
2.8	Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхэд болон асран хамгаалагч нарт эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах	Сургалтад хамрагдсан хүний тоо	522	550	100%	Эхний хагас жилийн байдлаар хэвтэн эмчлүүлж байгаа хүүхэд болон асран хамгаалагч нарт төвийн даргаар батлуулсан сургалтын төлөвлөгөөний дагуу ээлжинд хонож байгаа эмч, сувилагч нар 10 төрлийн сэдвээр 40 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 352 хүнд зохион байгуулсан.
		Зохион байгуулсан сургалтын тоо	23	25		
2.9	Өсвөр үеийхэнд эрүүл мэнд болон хөгжлийн барамжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Хамрагдсан сургууль, үйл ажиллагаа хэрэгжүүлсэн тоо	-	-	100%	1 болон 3 ангийн нийт 100 гаруй сурагчдад үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх “Бид найзууд” сургалт зохион байгуулсан. (Ерөнхий боловсролын 40 дүгээр сургуулийн 3е ангийн 30 гаруй сурагч, Улаанбаатар Элит сургуулийн 1а, b, c бүлгийн 72 сурагч хамрагдсан)
2.10	Эмчилгээ, оношлогоо, удирдамж, заавар болон түгээмэл үйлдлийн стандартын мөрдөлтөнд хуваарийн дагуу хяналтын хуудсаар хяналт хийж үр дүнг тооцох	Боловсруулсан хяналтын хуудасны тоо	4	6	100%	Эмчилгээ, оношлогоо, удирдамж, заавар болон түгээмэл үйлдлийн 36 стандартыг мөрдөн ажиллаж байна
		Хийгдсэн хяналт үнэлгээний тоо	4	5	100%	
		Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	100%	100%		
2.11	Сувилахуйн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, асаргаа сувилгааг чанартай үзүүлэх	Шинээр нэвтрүүлсэн төрлийн тоо	8	9	100%	Сувилахуйн тусламж үйлчилгээний төрлийг 1. Шархны иж бүрдэл -4ш 2 Амин үзүүлэлт үзэх иж бүрдэл -1ш зэрэг иж бүрдлүүдийг нэмж, ашиглан шинээр хийж тусламж үйлчилгээнд ашиглаж байна.
2.12	Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо	613	650	100%	ХУД-ийн 2-р хорооны 72-р цэцэрлэгт 3 сарын 10-14 нд Хүүхдийн хөгжлийн эрт илрүүлэг зохион байгуулсан. Тухайн үйл ажиллагаанд цэцэрлэгийн нийт 313 хүүхэд хамрагдсанаас Хэл ярианы хоцрогдолтой-29 Хөгжлийн хоцрогдолтой- 16 хүүхэд илэрсэн.

						Хүүхдийн үнэлгээний хуудсыг боловсруулан онош болон шаардлагатай эмчилгээг тэмдэглэж багш болон эцэг эхчүүдэд өгсөн.
2.13	Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэх	Шийдвэрлэлт ийн дундаж хоног	30 хоног	5 хоног	100%	НЗД-ын 2022 оны А/1049 тоот захирамж, Төвийн даргын 2022 оны А/69 тоот тушаалын дагуу иргэд, үйлчлүүлэгч, ажилчдаас ирүүлсэн өргөдөл гомдлыг дараах байдлаар шийдвэрлэж ажиллаж байна. 1.Байгууллага нэгж албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг төвийн 11-341598 дугаарын утсаар, байгууллагын  khantuul.ub.gov.mn цахим хаягаар, төвийн албан ёсны (3) Facebook - Хүүхдийн сэргээн засах Хан Туул төв фейсбүүк пейж хуудсаар болон санал хүсэлтийн хайрцагаар дамжуулан хүлээн авч холбогдох албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлж байна. 2.Тус байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг байгууллагын бичиг хэрэг бүртгэл хяналтын картаар хүлээн авч бүртгэн НЗД-ын 2022 оны А/1049 тоот захирамж болон төвийн даргын 2022 оны А/69 тоот тушаалын дагуу шийдвэрлэж байна. 3.Шийдвэрлэсэн байдал, хугацаа: Нэмэлт баримт, мэдээлэл бүрдүүлэх шаардлагагүй, өөрт байгаа мэдээлэл олгогдсон эрх үүргийн хүрээнд шийдвэрлэх боломжтой өргөдөл, гомдлыг 8 цагийн дотор, нэмэлт мэдээлэл бүрдүүлэх, өөр байгууллага, албан тушаалтнаас тодруулах лавлагаа авч шийдвэрлэх өргөдөл гомдлыг 5 хоногт багтааж, шалгуулж тодруулах шаардлагатай, ажлын хэсэг зөвлөл, комиссын хурлаар хэлэлцүүлэх шаардлагагүй өргөдөл гомдлыг бүртгэсэн өдрөөс хойш 15 хоног дотор, газар дээр нягтлан шалгах, судалгаа хийх, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах шаардлагатай, ажлын хэсэг зөвлөл, комиссын хурлаар хэлэлцүүлэх шаардлагатай
		Шийдвэрлэлт ийн хувь	100%	100%		

						өргөдөл гомдлыг бүртгэсэн өдрөөс хойш хуанлийн 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж байна. 4.Өргөдөл гомдлын хариуг утсаар, биечлэн уулзах, цахим, цаасан хэлбэрээр тухайн иргэнд хүргүүлэн ажиллаж байна. 5.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмын дагуу байгууллагын албан ёсны цахим хуудас болон ил тод байдлын мэдээллийн самбарт байршуулж улирал тутам өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг байршуулан ажиллаж хэвшсэн. 2026 оны хагас жилийн байдлаар дотоод албан хаагчдаас нийт -47 ирсэнээс 46 өргөдөл хөдөлмөрийн дотоод журмын дагуу 97% тай шийдвэрлэсэн 1 өргөдөл шийдвэрлэх хугацаандаа явж байна.
2.14	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдэлийг үнэлж, эрсдэлийг бууруулах	Эрсдэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	85%	86%	100%	2026 оны нэгдүгээр улиралд ЭМС-ын А/566 тушаалын 2-р хавсралт, төвийн даргын 2024.04.24-ны А/16 тушаалын дагуу Хантуул төвд тохиолдож болох эрсдлүүд , түүнд хийсэн үнэлгээ, төлөвлөлт гаргаж үр дүнг тооцож ажилласан. Эрсдлийг 8 төрлөөр нийт 62 тохиолдож болох эрсдлийн жагсаалт гаргасан. Үүнээс: Дунд түвшин -29 /46,77%/ Өндөр түвшин -19 /30,65%/ Ноцтой түвшин -14 /22,58%/ тус бүр тодорхойлсон. ЭМС-ын А/566 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрсдэлийг бүртгэх, хариу арга хэмжээ авах заавар” сэдвээр 2026 оны эхний улиралд Эрүүл мэндийн чанарын холбооноос 1 кредиттэй 2 өдрийн

						8 цагийн сургалтыг нийт 24 эмч мэргэжилтгүүд оролцсон. Аюулгүй байдлын тойрон үзлэгээр /2026.03.27/ хяналт хийж эрсдлийг дахин үнэлж нийт 8 чиглэлээр эрсдлийг бууруулах арга хэмжээг авч ажиллаж байна. Магадлан итгэмлэлийн хугацаа сунгах ажлын хүрээнд төлөвлөгөөний дагуу 2026 оны эхний улиралд Аян 1 удаа, АХА тэмцээн 1 удаа тус тус зохион байгуулсан. Эрүүл мэндийн чанарын холбоо, УХТЭ-ийн Яаралтай тусламжийн тасагтай хамтран дээрх чиглэлээр 2 удаагийн том хэмжээний сургалтанд давхардсан тоогоор 84 эмч, мэргэжилтэн, ажилтан хамрагдсан. Дотооддоо ажлын байрны тасралтгүй сургалтанд эмч, мэргэжилтний мэргэжлийн ур чадавхийг дээшлүүлэх 8 удаагийн сургалтанд 124 орчим мэргэжилтэн давхардсан тоогоор хамрагдсан. Эдгээр сургалтын үр дүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг аюулгүй, чанартай, үр дүнтэй, хүртээмжтэй, үйлчлүүлэгч төвтэй үзүүлж байна
2.15	2025 онд хийсэн “Сайн туршлага” арга хэмжээний бүтээлийг нутагшуулах	2025 оны арга хэмжээний шилдэг бүтээл нутагшуулсан тоо	1	3	100%	1.Хүүхдийн нурууны муруйлтийн оношлогоонд дижитал сколиометр аппликейшн ашигласан” нь сэдвээр хөдөлгөөн засалч Б.Очмаа, П.Чулуунчимэг нар илтгэл хэлэлцүүлж бүтээл нь “ Сайн туршлага 2025” номонд хэвлүүлсэн. Одоогоор нийт 8 хүүхдэд Дижитал сколиометрийн хэмжилтийг гар утасны апплейкешн ашиглаж нурууны муруйлтыг тодорхойлсон. 2.Улны скайн ашиглаж 4 хүүхдэд хавтгай тавхайн үнэлгээг хийсэн.
2.16	Ажилчдын сэтгэл ханамжийн судалгааг улирал тутам авч, холбогдох арга хэмжээг шийдвэрлэн хэрэгжүүлэх.	Хэрэгжилтийн хувь	88%	90%	100%	2026 оны I болон II дугаар улиралд байгууллагын ажилтнуудаас ажлын орчин нөхцөл, удирдлага зохион байгуулалт, ёс зүй харилцаа, цалин урамшуулал, нийгмийн баталгааны чиглэлээр
		Авч хэрэгжүүлсэн арга	20%	100%		

		хэмжээний хэрэгжилтийн хувь			сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг нэгтгэн дүгнэв. НЭГ. I ДҮГЭЭР УЛИРЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН I дүгээр улирлын судалгаанд нийт 25 ажилтан хамрагдсан бөгөөд байгууллагын дотоод сэтгэл ханамжийг 36 асуултаар үнэлсэн. Судалгааны дүнгээр: - Нийт оролцогчдын 68% нь эерэг үнэлгээ өгсөн бол 32% нь дунд гэж үнэлсэн. - Ажилчдын 84% нь ажилдаа сэтгэл хангалуун гэж хариулсан. - Удирдлагын үйл ажиллагаанд 60% нь эерэг үнэлгээ өгсөн боловч 36% нь дунд болон муу үнэлгээ өгсөн байна. - Ёс зүй, харилцааны асуудлыг 48% нь дунд түвшинд, 16% нь муу гэж үнэлжээ. - Нийгмийн хангамжийг 56% нь дунд, 28% нь хангалтгүй гэж үнэлсэн байна. Мөн ажилтнууд: - үндсэн цалинг нэмэх, - ажлын үр дүнг шударгаар үнэлэх, - цалинтай өдрийн чөлөө олгох, - байр, орон сууцны дэмжлэг үзүүлэх, - хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилласны нэмэгдэл олгох зэрэг санал гаргасан. ХОЁР. II ДУГААР УЛИРЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН II дугаар улирлын судалгаанд нийт 28 ажилтан хамрагдсан. Судалгааны дүнгээс: - Ажлын байрны орчин тав тухтай байдлыг 89.3% нь “Сайн” болон “Маш сайн” гэж үнэлсэн.
--	--	-----------------------------------	--	--	--

					• Тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний хүрэлцээг 71.4% нь эерэгээр үнэлсэн. • Ажилдаа сэтгэл ханамжтай байдлыг 82.1% нь “Сайн” болон “Маш сайн” гэж үнэлсэн. • Байгууллагадаа тогтвортой ажиллах хүсэлтэй ажилтан 89.3% байна. Харин: • Албадын даргын харилцаа, хандлагыг 10.7% нь хангалтгүй, • Ёс зүй, үл хүндэтгэсэн харилцааг 14.3% нь хангалтгүй гэж үнэлсэн байна. Нээлттэй санал асуулгаар: • Албадын дарга нарын ёс зүй, • Харилцаа хандлага, • Ялгаварлан гадуурхалт, • Мэдээллийн ойлгомжгүй байдал, • Хамт олны уур амьсгал, • Багаар ажиллах чадвар зэрэг асуудлыг сайжруулах шаардлагатай гэж үзжээ. Мөн: • Ёс зүйн сургалт зохион байгуулах, • Ажилтны санал хүсэлтийг сонсох, • Ипотекийн болон орон сууцны дэмжлэг үзүүлэх санал гарсан байна. ГУРАВ. ХАГАС ЖИЛИЙН НЭГДСЭН ДҮГНЭЛТ 2026 оны хагас жилийн судалгааны дүнгээс харахад байгууллагын ажилтнууд ажлын орчин нөхцөл, байгууллагын үйл ажиллагаа, ажилдаа хандах хандлагад ерөнхийдөө сэтгэл ханамжтай байгаа нь харагдаж байна. Ялангуяа: • Ажлын байрны орчин, • Байгууллагын тогтвортой үйл ажиллагаа, • Цалин урамшууллын тогтолцоо,
--	--	--	--	--	---

						- Хүүхдэд үзүүлж буй сэргээн засах тусламж үйлчилгээний ач холбогдлыг эерэгээр үнэлсэн байна. Харин дараах чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд: - Албадын дарга нарын ёс зүй, харилцаа хандлага, - Хамт олны уур амьсгал, - Мэдээллийн ил тод байдал, - Багаар ажиллах соёлыг сайжруулах асуудал багтаж байна.
2.17	Эмнэлгийн тусламж үйлчилгээний бүртгэгдсэн тохиолдлын шийдвэрлэх	Тохиолдол давтагдахаас сэргийлэх арга хэмжээний тайлан	6	Тухай бүр	100%	2026 оны 1-р улиралд 8 алдах дөхсөн тохиолдол бүртгэгдсэн. Тохиолдлыг илрүүлсэн байдал: - о эмч, ажилчдаас –5 - о чанар, сувилахуй, халдвар хяналтаар хяналтаар -3 Гарсан үр дагавар тохиолдол бууруулах чиглэлээр залруулах арга хэмжээ: 1.Эмийн аюулгүй байдал болон зөв танин тодруулгаар нийт 2 удаа дотоод сургалт хийгдсэн.Давтан эмтэй холбоотой тохиолдол бүртгэгдээгүй. 2.Тохиолдлыг бүртгэдэг,бүртгэлтэй. одоогоор цахим системд 2 тохиолдол бүртгэгдсэн
		Тохиолдлын бүртгэлийг цахим бүртгэлд бүртгэх бүртгэлийн тоо	-	Тухай бүр		
2.18	Эрүүл мэндийн ажилтныг жилд 1 удаа эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, эмнэлгийн оношилгоонд хамруулах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	Үзлэг шинжилгээнд хамрагдсан ажилтны тоо	29	29	100%	Хүүхдийн сэргээн засах Хан Туул төвийн ажилчдын 2026 оны хагас жилд зохион байгуулсан урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд үндсэн болон гэрээт нийт 37 ажилтан 100% бүрэн хамрагдсан байна. Шинжилгээний нэгдсэн дүнгээр нийт ажилчдын 10.8% буюу 4 ажилтанд вируст гепатит В, 5.4% буюу 2 ажилтанд вируст гепатит С илэрсэн байна. Шинээр ажилд орсон ажилтан, албан хаагчдыг “Эрүүл мэндийн хуудас”-ыг хөтөлж, хуудсыг хувийн хэрэгт хавсаргаж, дархлаажуулалтын мэдээллийн санг бүрдүүлж, В, С, Д вируст гепатит, ХДХВ, сүрьеэгийн халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан.
		Эрүүлжилтийн хувь	-	Тухай бүр		

2.19	Халдвараас сэргийлэх журам, зааврын дагуу хяналт, үнэлгээний шалгуур хуудсыг боловсруулан хяналтыг эрчимжүүлэх	Хэрэгжилтийн хувь	92%	93%	100%	Төвийн даргын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/26 тоот тушаалаар батлагдсан хяналтын хуудасны дагуу 9 удаагийн хяналтыг хийсэн. Батлагдсан хуваарийн дагуу халдвараас сэргийлэх хяналт үнэлгээг хийхэд хэрэгжилт 91% байлаа. 1.“Эрүүл мэндийн ажилтны гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадлыг үнэлэх хяналтын хуудас”-аар 2 удаагийн хяналтаар давхардсан тоогоор 32 ажилтан хамрагдаж, дундаж үнэлгээ 85% гарсан. 2.“Гар угаах, халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байдлыг үнэлэх хяналтын хуудас”-аар үнэлэхэд гар угаах нөхцөл, хангамж 90%-тай байсан. 3.“Цэвэрлэгээний чанарт дотоод хяналт хийх хуудас”-аар 3 удаагийн хяналт хийж, дундаж үнэлгээ 80%-тай байсан. 4.“Гал тогооны халдвар хамгааллыг шалгах хяналтын хуудас”-аар 2 удаагийн хяналт хийж бага эрсдэлтэй үнэлэгдсэн. 5.“Халдвартай хог хаягдлын үйл ажиллагааг хянах хяналтын хуудас”-аар 1 удаагийн хяналт хийж, хэрэгжилт 95% байсан. Дээрх хяналтын үнэлгээнд үндэслэж хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулж ажиллаж байна.
2.20	Халдвар хамгааллын чиглэлээр тогтмол сургалт зохион байгуулж, чадавхижуулах	Сургалтын тоо, хамрагдсан ажилчдын хувь тайлан	88%	89%	100%	Халдварын сэргийлэлт, хяналтын (ХСХ) чиглэлээр нийт 4 удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулж, тус сургалтуудад давхардсан тоогоор нийт 35 ажилтан, албан хаагч хамрагдан, холбогдох

					заавар журмын дагуу практик дадал, мэдлэгийг эзэмшлээ. 1.Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29 ны өдрийн Заавар батлах тухай 537 тоот тушааын 1 дүгээр хавсралт /Гар угаах, халдваргүйжүүлэх заавар/-ын дагуу 2026 оны 3 сард Гар угаах, халдваргүйжүүлэх сэдэвт сургалтыг 1 удаа зохион байгуулж, 16 ажилтан, албан хаагчид хамрагдаж, гар зөв угааж, халдваргүйжүүлэх дадал эзэмшүүлсэн. 2. Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29 ны өдрийн Заавар батлах тухай А/537 тоот тушаалын 3 дугаар хавсралт /Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх заавар/-ын дагуу Өртөлт, өртөлтийн дараах сэргийлэлт сэдэвт сургалтыг 2026 оны 4 сард нийт 18 ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулсан. 3.Эрүүл мэндийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай А/173 тоот тушаалын дагуу нийт ажилтан, албан хаагчдын дунд 2026 оны 4 сард Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент сэдэвт сургалтыг 1 удаа зохион байгуулж 15 ажилтан, албан хаагчид хамрагдаж, хог хаягдлыг зөв ангилан ялгаж хэвшсэн. 4. Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29 ны өдрийн Заавар батлах тухай А/537 тоот тушаалын 7 дугаар хавсралт / Хамгаалах хувцас, хэрэгсэл хэрэглэх заавар /-ын дагуу 2026 оны 4 сард Хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөж тайлах дараалал сэдэвт 1 удаагийн сургалтыг 18 ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулж, хамгаалах
--	--	--	--	--	--

						хувцас хэрэгслийг зөв өмсөж, тайлах дадлыг эзэмшүүлсэн
2.21	Хөгжлийн хоцрогдолтой хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийг үнэлсэн хүүхдийн тоо	Урт хугацааны эмчилгээний хяналтын тоо Богино хугацааны эмчилгээний хяналтын тоо Эрүүлжилтийн хувь	- - 88%	Тухай бүрд Тухай бүрд 90%	100%	2026 оны эхний 5 сард нийт 839 хүүхэд тусламж үйлчилгээнд хамрагдсан байна.Үүнд: Өдрийн эмчилгээнд -201хүүхэд, Урт хугацааны буюу давтан -234 хүүхэд , - Богино хугацааны буюу анх -404 хүүхэд хамрагдсан. - Хөдөлгөөн засал эмчилгээнд ахицын үнэлгээний хувь-82% - Хэл засал эмчилгээнд ахицын үнэлгээний хувь-67% - Хөдөлмөр засал эмчилгээнд ахицын үнэлгээний хувь-92%
2.22	Төвийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр боловсруулж, арга хэмжээг тасралтгүй зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний төрөл	2	3	100%	Төвийн үйл ажиллагааны онцлогт тохируулан “Урлахуйн хөтөлбөр” боловсруулан батлуулж хүүхдийн сэтгэн бодох чадвар, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөх, хүүхэд хүүхдээсээ суралцах чадварыг дэмжих зорилготойгоор усан будаг, гуаш, харандаа, пламастер, хайчилбар, наамал, нугалбар зэргээр бүтээл хийлгэж байна. Энэхүү хөтөлбөрт 2026 оны эхний хагас байдлаар хэвтэн эмчлүүлэгч 127 хүүхэд хамрагдсан.
2.23	Байгууллагын пейж хуудас, веб сайтад сэргээн засах эмчилгээ, асаргааны талаарх мэдээллийг тогтмол хийж хөгжүүлэлтийг хангах	Байршуулсан мэдээллийн тоо	121	130	100%	Байгууллагын пэйж хуудсанд төвийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, сургалт, ЭМБО мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж байна. Эхний хагас жилийн байдлаар 62 төрлийн мэдээ мэдээлэл байршуулан 86,336 хандалт авсан. Веб хуудасны засварын ажлыг төвийн гэрээт ИТ хийж байна.
2.24	Эрүүл мэндийн ажилтныг ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж гадаад, дотоод сургалтад хамруулах	Сургалтанд хамрагдсан эмч, ажилчдын хувь	6	7	100%	Төвийн 2026 оны сургалтын төлөвлөгөөг батлуулан 05 сарын 27-ны байдлаар төлөвлөгөөний дагуу 15 төрлийн сургалтыг давхардсан тоогоор 264 ажилтнуудад зохион байгуулсан. Үүнээс гадаад сургалт 7, дотоод сургалт 8 удаа зохион байгуулсан.

2.25	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах	Биелэлтийн хувь	85%	90%	100%	Хан-Уул хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн алсын хараа, эрхэм зорилго, хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, сонгон шалгаруулах, үнэлэх, чадавхжуулах, тогтвор суурьшилтай боловсон хүчин бий болгох зорилгоор ажилтан, албан хаагчдын авьяас чадварыг хөгжүүлэх, сургаж мэргэшүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр 2026–2029 оны Хүний нөөцийн хөгжлийг хангах хөтөлбөрийг 2026 оны эхэнд батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2026 оны хагас жилийн биелэлтийг үнэн зөв тайлагнаж 2026.06.05-ны өдөр Нийслэлийн эрүүл мэндийн газарт албан бичгээр хүргүүлэн ажилласан.
2.26	Шинээр ажилд орсон ажилтнуудын мэргэжилтнүүдийг шинэ ажилтны хөтөлбөрт хамруулах	Шинээр ажилд орсон ажилчдад зохион байгуулсан сургалтын тоо	Тухай бүрд	Тухай бүрд	100%	Төвийн даргын 2026 оны 04 дүгээр сарын 16 -ний өдрийн А/13 тоот тушаалаар “Шинэ ажилтны чиглүүлэх, дасан зохицох хөтөлбөр”-ийг батлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Сургалтыг хөтөлбөрийн дагуу Шинэ ажилтныг чиглүүлэх сургалт нь дараах хөтөлбөр, агуулгын хүрээнд зохион байгуулагддаг. Үүнд: • Байгууллагын танилцуулга • Удирдлагын танилцуулга • Төвийн бүтэц, зохион байгуулалт • Бичиг хэрэг хөтлөлт болон архивын үйл ажиллагаа • Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”, хөдөлмөрийн гэрээ • Халдвар сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаа • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй сургалт • Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөлтийн журам • Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, дүрэм стандарт • Эмнэлгийн дотоод сүлжээ ашиглалт болон эмнэлзүйн программ ашиглалт

						2026 оны хагас жилийн байдлаар 9 ажилтан шинээр орж ажилласан бол үүнээс 1 эмч, 1 сувилагч, 3 мэргэжилтэн, 4 гэрээт ажилтан захиргаанд шинээр орсон. Шинээр ажилд орж буй ажилтнуудтай Хүний нөөцийн менежер биечлэн уулзаж, бүрдүүлэх материал, анхаарах асуудлууд, эрх зүйн зохицуулалтуудын талаар танилцуулан асуултанд хариулж, тайлбарлан нээлттэй ярилцаж, зөвлөгөө, зааварчилгааг өгч хэвшсэн. Үүний үр дүнд байгууллагын талаар цэгцтэй ойлголттой болж, богино хугацаанд дасан зохицож, хамт олны нэг хэсэг болж чадах ба цаашлаад хүний нөөцийн тогтвортой байдлыг бүрдүүлсэн. Мөн ёс зүй, харилцаа хандлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажиллагаа болон халдвар хамгааллын чиглэлээр баримтлан ажиллах нэгдсэн ойлголттой болдог.
2.27	Эрүүл мэндийн ажилтны стрессын түвшинг тодорхойлох, арга хэмжээг зохион байгуулах	Сургалтын тоо	-	2	100%	Эрүүл мэндийн ажилтны стрессийн түвшинг тодорхойлох, бууруулах арга хэмжээний хүрээнд эмч, ажилтны сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, сэтгэл хөдлөлийн ачааллыг бууруулах, ажлын байрны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллалаа. 1. Арт терапийн “Канвас Арт” сургалт, үйл ажиллагаа 2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр эмч, ажилтны сэтгэл зүйн байдлыг дэмжих зорилгоор Арт терапийн чиглэлийн “Канвас Арт” сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 22 эмч, ажилтан хамрагдсан. 2. Дуут аялгуун бүлгийн болон ганцаарчилсан эмчилгээ 2026 оны 05 дугаар сарын 06, 13, 14-ний өдрүүдэд эмч, ажилтнуудад зориулсан Дуут аялгуун (Sound Healing) бүлгийн эмчилгээнд нийт 19 хүн хамрагдсан. Ганцаарчилсан эмчилгээнд 4 хүн хамрагдсан.
	“Сувилагч болмоор байна” эссэ бичлэг	Хэрэгжилтийн хувь	-	100%	100%	Дэлхийн сувилагчийн өдрийг тохиолдуулан ЕБС-ын 18-р сургуулийн ахлах ангийн 200 хүүхдэд эссе бичлэгийн уралдаан зарлаж 3 эссе шалгаруулж Өргөмжлөл, үнэ бүхий зүйлийг дурсгасан.

2.28	Тусламж үйлчилгээ чанарын өвөрмөц үзүүлэлтийг боловсруулан батлуулах, дүн шинжилгээ хийх	Хэрэгжилтийн хувь	-	100%	100%	Хүүхдийн сэргээн засах Хантуул төвийн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтийг төвийн даргын 2026 оны А/14 тушаалаар чанарын шалгуур үзүүлэлтийг бодох аргачлалыг хавсралтаар тус тус боловсруулан батлуулсан.Тусламж үйлчилгээний төрөл бүрийг хамруулан нийтлэг 18 үзүүлэлтээр, өвөрмөц 3 шалгуур үзүүлэлтээр /нийт -22/ гаргасан.2026 оны эхний улиралд үнэлгээг хийсэн. хэрэгжилт-100%
2.29	Хэвтэн эмчлүүлж байгаа хүүхдүүдэд сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хүүхдийн тоо		100%	100%	Байгууллагын хэмжээнд хүүхдийн эрүүл зөв хооллолтыг дэмжих, шим тэжээлийн хэрэгцээг хангах зорилгоор “Сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 46 хүүхдийг хамруулаад байна. Хөтөлбөрийн хүрээнд долоо хоног бүрийн 2, 4, 5 дахь өдрүүдэд 16:00 цагт хөөрүүлсэн сүү, хярам, харин 1 болон 3 дахь өдрүүдэд тараг олгож, хүүхдийн сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэн ажиллаж байна.
2.30	Бага насны хүүхдийн суурь өвчлөл, хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлж, хоол эмчилгээнд хамруулж суурь өвчлөлийг бууруулах	Хоол тэжээлийн цочмог дутагдал илрүүлэгт хамрагдсан хүүхдийн тоо	-	Тухай бүрд	100%	Хоол тэжээлийн цочмог дутагдалтай 7 хүүхдийг илрүүлэн хэвтэн эмчлүүлж буй эмчилгээний хугацаанд 14 хоногийн турш уураг, илчлэгээр баяжуулсан хоол бэлтгэн олгож. эмчилгээний үр дүнг 7 хоног тутам үнэлж, хяналт тавин ажилласан бөгөөд хүүхдүүдийн жин дунджаар 200 граммаар нэмэгдсэн эерэг үзүүлэлт гарсан. Мөн асран хамгаалагч нартай хамтран ажиллаж, хүүхдийн зөв хооллолт, хоол тэжээлийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилсан.
		Илрүүлсэн хүүхдийн тоо, хувь	-	50%		
		Эрүүлжилтийн хувь		50%		
2.31	Зонхилон амьсгалын зам, тохиолдох гэдэсний бактерит, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн	Боловсруулсан мэдээллийн тоо	12	15	100%	Хүүхдийн суулгалт өвчин, уушгины хатгалгаа, хүүхдийн эрүүл мэндэд чихрийн хэрэглээний үзүүлэх сөрөг нөлөө, эхийн сүүний ач холбогдол, улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зэрэг сэдвээр эрүүл мэндийн боловсрол

	боловсрол олгох үйл ажиллагааг, хэрэгжүүлэх Шалгуур: батлагдсан өвөрмөц үзүүлэлт	Цахим болон цаасаар хүргэсэн тоо	30	35		олгох брошюр боловсруулж, мэдээллийн самбарт байршуулсан. Түүнчлэн өдрийн болон хэвтэн эмчлүүлж буй хүүхдүүдийн асран хамгаалагч нарт өвчнөөс урьдчилан сэргийлэх, зөв хооллолт, дархлаажуулалт, хүүхэд асаргаа сувилгааны талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаж байна. Эхний хагас жилийн хугацаанд улаанбурхан өвчин болон хүүхдийн халдварт, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор эцэг эх, асран хамгаалагчид болон олон нийтэд чиглэсэн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тогтмол байршуулан түгээж ажиллаа. Үүнд, 1 дүгээр сард улаанбурхан өвчний талаар 2 мэдээлэл нийтэлж 1482 хандалт, 2 дугаар сард хоолны хордлогын талаар мэдээлэл байршуулж 589 хандалт, 3 дугаар сард иодын ач холбогдол болон хүүхдийн оюуны хөгжлийн талаарх мэдээлэл нийтэлж 249 хандалт тус тус авсан. Мөн 4 дүгээр сард аутизмыг таниулах, 5 дугаар сард дархлаажуулалтын талаарх мэдээллийг байршуулан ажилласан.
3.1	Төвийн 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Хэрэгжилтийн хувь	0	20%	100%	Хүүхдийн сэргээн засах Хан Туул төвийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн хөгжлийн хөтөлбөр, 3 жилийн Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргаар 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна
3.2	Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, ил тод байдлыг хангах	Санхүүгийн зөрчилгүй ажилласан байдал	100%	100%	100%	Засаг даргын даргын тамгын газрын даргын тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Нийслэлийн дотоод аудитын газраас ирсэн хяналт шинжилгээнд 2024, 2025 оны санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтээр 164,375,300₮-ийн зөрчил илэрсэн ба үүнээс 95,831,300₮-ийн акт, 68,544,000₮-ийг зөвлөмжөөр хүргүүлсэн байна. Тухайн ажлын хүрээнд холбогдох хүмүүст арга хэмжээг авахаар ажиллаж байна. Төсвийн сар бүрийн зарцуулалт гүйцэтгэлийн мэдээ, тайланг шилэн дансны сайт

						болон мэдээллийн самбарт ил тод байршуулж байна.
3.3	Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж, төрийн өмчийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, тайлагнах	Оруулсан мэдээллийн хувь	97.1%	98%	100%	Тооллогыг төвийн даргын 2025 оны 12-р сарын 24-ний өдрийн А/47 тоот тушаалын дагуу хөрөнгө худалдан авах, хөрөнгө бүртгэх зэрэгт ӨХБЗ тухай бүр хуралдан, зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжсон. 2026 онд эд хөрөнгийн ашиглалтын картыг тасаг нэгж, албан хаагч бүрээр шинэчлэн гаргаж, хөрөнгийн ашиглалт хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. 2026 оны эхний хагас жилийн тооллогыг 05 сарын 25-наас 05 сарын 29 өдрүүдэд тооллогын комисс тооллогыг хийж дуусгалаа.
3.4	Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангах холбогдох сайтад мэдээллийг хугацаанд нь байршуулах	Байгууллагын шилэн дансанд оруулсан мэдээллийн хувь	97,1%	98%	100%	shilen.gov.mn -сайтын 2026 оны 1-р улирлын мэдээллийг нээлттэй ил тод байршуулан 61,56%-тай үнэлэгдсэн. Үнэлгээ хийсэн мэргэжилтний зааврын дагуу 2026 оны 2-р улирлын тайланг мэдээллийг хугацаанд нь байршуулахаар ажиллаж байна.
		/shilen.gov.mn / -сайтын мэдээллийн ил тод байдал	17%	85%		
3.5	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.	Санхүүгийн зөрчилгүй ажилласан байдал	Санхүүгийн зөрчилгүй ажилласан.	Санхүүгийн зөрчилгүй ажилласан байна	100%	2026 оны байдлаар зөрчил, дутагдалгүй ажиллаж байна.
3.6	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.4.6 дахь заалт “Төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлэх, хувийн хэвшлийг дэмжих тогтолцоог бүрдүүлэх”, ногоон худалдан авах ажиллагааг зохион байгуулах.	Гүйцэтгэлийн хувь	100%	100%	100%	Төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжилт хэрэгжих “Хүнсний материал нийлүүлэх” худалдан авах ажиллагааг Төвийн даргын А/11 тоот тушаалаар 2026 оны 04 сарын 16нд зохион байгуулж, Гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгон 2026 оны 5 сарын 19-нд Хүнсний материал нийлүүлэх №ХСЗХУТ/20260202001 тоот гэрээ 1 жилийн хугацаатай байгуулан, гэрээний дагуу ажиллаж байна.
3.7	Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар	Төрийн худалдан авах	100%	100%	100%	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу Төрийн

	тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдснаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнана.	ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу тайлагнасан байдал				худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааг төлөвлөн 2026 оны 4 сарын 20-нд зарлаад 30-нд нээсэн компани орж ирээгүй, дахин 5 сарын 1 нд зарласан. “КУКУ АГРО” ХХК орж ирж гэрээ байгуулах эрхийг 5 сарын 19-нд олгосон.
3.8	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах.	Төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж ажиллана	Өр-13.534.0	50%	100%	Батлагдсан төсвийн зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх тал дээр ажиллаж байгаа ба өр, авлагын мэдээг хуулийн хугацаанд НЭМГ-т тайлагнан ажиллаж байна.
3.9	2027 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд хүргүүлэх	Төсвийн төсөөлөл хүргүүлсэн байх	100%	100%	100%	2027 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд нь хүргүүлэхээр алба, нэгжээс санал аван ажиллаж байна.
3.10	2027 оны тогтмол зардлын төсвийн төсөл	Төсвийн тухай хууль	100%	100%	100%	2027 оны тогтмол зардлын төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд нь хүргүүлэхээр ажиллаж байна..
3.11	Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд ирүүлэх.	Санхүүгийн тайлан	2	2	100%	Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд эхний хагас жилээр гаргахаар ажиллаж байгаа.
		Төсвийн тайлан	12	12		
3.12	2025 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, зөвлөмж, албан шаардлагыг	Зөвлөмжийн дагуу төлөвлөгөөний	100%	100%	100%	2025 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын шалгалтаар 5 зөвлөмж 2 төлбөр барагдуулах акт тавигдсан. Зөвлөмжийн дагуу төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байгаа мөн төлбөр барагдуулах акттай холбоотой тухайн төлбөрийг

	хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	хэрэгжилтийн хувь				Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сангийн дансанд байршуулахаар ажиллаж байна.
3.13	Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.2 дахь заалтын дагуу өндөр насны тэтгэвэрт гарч байгаа албан хаагчдын ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн материалыг бүрдүүлж өгөх	Материал бүрдүүлж өгсөн албан хаагчдын тоо	1	Тухай бүрд	100%	Тайлант онд тус төвөөс өндөр насны тэтгэвэр тогтоолгох албан хаагчийн хүсэлт ирүүлээгүй байна. 2027 онд өндөр насны тэтгэвэрт гарах 4 албан хаагчийн судалгааг гаргаж, тэтгэвэр тогтоолгох болон нэг удаагийн мөнгөн тэтгэмж авахад шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хангах бэлтгэл ажлыг зохион байгуулж байна.
3.14	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэвшүүлэх, баримтлан ажиллахад чиглэсэн үйл ажиллагааг байгууллагын удирдлага манлайлан, Ёс зүйн хэсгийн хорооны дэмжлэгтэйгээр тогтмол хэрэгжүүлэх	Ёс зүйн хэсгийн хороо байгуулах	1	1	100%	2026.05.15-нд Монголын үйлдвэрчний эвлэлийн хуульч М.Саранцацрал “Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” сэдвээр төвийн 30 ажилтанд сургалт зохион байгуулсан.
		Сургалтад хамруулах хүний тоо	30	30		

3.15	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030 он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	2	2	100%	Авлигатай тэмцэх ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх комиссар С. Янжинлхамтай хамтран төвийн 22 ажилчдад “Авлигын эсрэг суурь ойлголт, мэдээлэл” сэдэвт сургалтыг 2026 оны 02 сарын 10-ны өдөр зохион байгууллаа. - “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх нь” - “Авлигын шалтгаан нөхцөл, хор хөнөөл” зэрэг сэдвээр дэлгэрэнгүй танилцуулга, мэдээлэл хийж сургалтад оролцогчдын асуултад хариулж, авлигаас урьдчилан сэргийлэх талаар мэргэжил, арга зүйн заавар, зөвлөгөө өгөв.
3.16	Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III” хүрээнд албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлж, байгууллагын албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөх.	Хос бичгээр хөтөлсөн албан бичгийн хувь	50%	90%	100%	Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”, Засгийн газрын 2022 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2025 оны 01 сарын 01-ний өдрөөс хос бичгээр хөтлөх үүрэг даалгавар ирснээс 1 ажилтанг дадлагажуулан, 2 дугаар улирлаас хойш албан бичиг хос бичгээр, 2026 оны 01 сараас албан бичиг болон захирамжлалын баримтуудыг монгол бичгээр албан хэрэг хөтлөн явуулан ажиллаж байна.
		Монгол бичгийн сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	80%	90%	100%	
3.17	“Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” 2025 оны зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулж, үйл ажиллагааг сайжруулах	Хэрэгжилтийн хувь	80%	90%	100%	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 23 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Улсын үзлэг зохион байгуулах тухай” А/1220 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн хэмжээнд төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийг Хүүхдийн сэргээн засах Хан-Туул төвд 2025 оны 12 дугаар сарын 16-

					ний өдөр хяналт шалгалт хийсэн. Үүрэг даалгаврын хэрэгжилт Төвийн даргаар 2026 оны 3 сарын 01-ний өдөр төлөвлөгөө боловсруулан батлуулж хийгдсэн ажилын хүрээнд: Төрийн байгууллагын зохион байгуулалтын хүрээнд Байгууллагын стратеги төлөвлөгөөг нийслэлийн эрүүл мэндийн газрын даргаар 2026-03-25 ны өдөр 2025-2028 оны хүрээнд 3 жилээр батлуулан ажилласан. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын дагуу төлөвлөгөө тайланг боловсруулан хэвшсэн. Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1. “Төрийн жинхэнэ албан хаагч хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс батлан мөрдөж хэвшсэн. Албан хаагчдын архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтад хамруулах, архив бичиг хэрэг хариуцсан ажилтныг давтан мэрэгшүүлэх чиглэлээр Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1692 дугаар захирамжаар нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглагдаж буй албан хэрэг хөтлөлтийн “eDoc” системийг сайжруулах, V.1.0.9.1 хувилбарыг хөгжүүлж, нэвтрүүлэх шийдвэр гарсан. Дээрх шийдвэрийн хүрээнд “eDoc” системийг V.1.0.9.1 хувилбарт шилжүүлэх туршилтын ажлыг бүрэн хийж дуусган, 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллах сургалтад байгууллагын удирдлага болон албан хаагчид нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй сургалтад хамруулсан. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг Архивын ерөний газрын 2026 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Архивын ерөнхий газрын даргын 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн
--	--	--	--	--	---

						A/43 Албан хэрэг хөтлөлт архивын ажилтан мэргэшүүлэх сургалтад Н.Отгонтөгс хамрагдаж мэргэшлийн үнэмлэх авсан. Баримт бичгийн загвар, хуудасны захын хэмжээ, дугаарлалт, хүснэгтийн мөр ба баганын дугаарлалт хийх ажиллагааг MNS 5140-3:2021 стандартын дагуу 2025 оны 1 сараас эхлэн Хос бичгээр Албан бичиг болон Төвийн даргын А, Б тушаалыг нөхөн хос бичгээр хөрвүүлэн байгууллагын архивд хүлээлгэн өгсөн. Байгууллагад үлдэх бүх эх хувь болон хавсралт баримт бичигт “боловсруулсан, хянасан” тэмдэглэлийг MNS 5140-2:2021 стандарт, стандартын дагуу боловсруулж байгаа албан хаагч болгонд зөвлөмж хүргэн ажиллаж байна. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг дүгнэх үзүүлэлт, аргачлал Байгууллагын архивын үйл ажиллагааг дүгнэх үзүүлэлт, аргачлал Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтыг дүгнэх үзүүлэлт аргачлал зөвлөмж болон албан шаардлагын чиглэлээр хавтас нээн холбогдох гарын авлага, хийж гүйцэтгэсэн ажлуудаа хавтас үүсгэн холбогдох журмын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн үүрэг даалгаврын биелэлтийг 2026-06-25-ний өдөр Нийслэлийн архивын газарт хүргүүлэхээр ажиллаж байна.
3.18	Дээд газраас ирсэн судалгаа, тайлан, мэдээ, тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь гаргаж ажиллах	Ирүүлсэн мэдээ тайлан, судалгааны хувь, тоо Шийдвэрлэсэн байдал	96%	98%	100%	Дээд газраас 2026-06-05-ны байдлаар ирсэн бичиг 124 байгаагаас шийдвэрлэсэн-118, Судалж байгаа-6 бичиг байна. Хугацаандаа шийдвэрлэсэн-116 93,55% Судалж байгаа-6, 4,84% Хугацаа хэтэрч хаагдсан-2, 1,61% -ийн хэрэгжилттэй ажиллаж байна. Системид нийтдээ 275 хуудас цаас хэмнэсэн байна.
3.19	Осол, гамшгаас урьдчилан төлөвлөгөөг сэргийлэх	Хэрэгжилтийн хувь	85.5%	90%	100%	Нийтийг хамарсан гамшгийн төлөвлөгөөнд тодотгол хийж, төвийн даргын 2023 оны А/31 тоот “Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги шинэчлэн байгуулах

	тодотголоор боловсруулж хэрэгжилтийг сайжруулах					тухай” тушаалыг 2026 оны 05 сарын 08 ны А/23 тушаалаар шинэчлэн батлуулсан. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг холбогдох ажилтнуудад танилцуулсан. 2026 онд нийт 39 хийхээр төлөвлөгдсөн. 06 сарын байдлаар 35 ажил хийгдсэн байна. ХУД-ОБХ урьдчилан сэргийлэх-асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Энхжаргал Осол, гамшгаас урьдчилан сэргийлэх сэдэвт сургалт 35 албан хаагч ажилтанд хийсэн. Дотоод сургалтаар 74 ажилтанд гал гарсан үед галын хор хэрхэн ашиглаж унтраах, ус үерээс сэргийлэх сургалт хийлээ. Мөн 2025 оны 10-р сард төвийн хэмжээний бүх галын хорыг шалгаж, нийт 4 хорыг мэргэжлийн байгууллагаар цэнэглүүлсэн, автомат галын хорыг Архив бичиг хэргийн өрөөнд шинээр авч байршуулсан.
3.20	Төвийн ажилчид, албан хаагч нарыг халдварт өвчний эсрэг дархлаажуулалтанд хамруулах	-Томуу томуу тест өвчлөл -Улаан бурхан -Гепатит дархлаажуулалтад хамрагдсан ажилтны тоо	29	29	100%	Хүүхдийн сэргээн засах Хан Туул төвийн ажилчдын 2026 оны хагас жилд зохион байгуулсан урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд үндсэн болон гэрээт нийт 37 ажилтан 100% бүрэн хамрагдсан байна. Шинжилгээний нэгдсэн дүнгээр нийт ажилчдын 10.8% буюу 4 ажилтанд вируст гепатит В, 5.4% буюу 2 ажилтанд вируст гепатит С илэрсэн байна. Шинээр ажилд орсон ажилтан, албан хаагчдыг “Эрүүл мэндийн хуудас”-ыг хөтөлж, хуудсыг хувийн хэрэгт хавсаргаж, дархлаажуулалтын мэдээллийн санг бүрдүүлж, В, С, Д вируст гепатит, ХДХВ, сүрьеэгийн халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан. 2026 оны I хагас жилийн байдлаар Хан Туул төвийн нийт ажилчдын 51.3 хувь (19 ажилтан) гепатит В-ийн вакцины бүрэн тунтай, үлдсэн 48.7 хувь (18 ажилтан) урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамрагдсан бөгөөд тэднийг дараагийн шатны вакцинжуулалтад хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.
3.21	Төвийн гадна ногоон байгууламжийг нэмэгдүүлж тохижуулах	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	240 мкв	100 мкв	100%	Төвийн гадна хойд талбайд шинээр 100 мкв талбайг зүлэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, 2025 оны “Тэрбум мод” тарих үндэсний өдөр зарлах тухай” 44 дүгээр зарлиг, Засгийн газрын 2021 оны “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга

						хэмжээний тухай” 350 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын ахалсан Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 01 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2026 оны 02-02/2523 дугаар чиглэл хүргүүлэх тухай “2026 оны хаврын мод тарих арга хэмжээний төлөвлөгөө”-ний дагуу СХД 21-р хороонд байрлах Инчөөн ногоон төгөлд очиж байгууллага хамт олноороо 2 нэр төрлийн 32 мод шинээр суулгаж тарьсан.
3.22	Ажилчдын ажлын гүйцэтгэлийг үр дүнг Удирдлагын зөвлөлөөр хэлэлцэж, урамшуулал олгох	Урамшуулал олгосон ажилчдын тоо	45	43	100%	Байгууллага нь албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, идэвх санаачилга, бүтээлч оролцоог тогтсон шалгуур үзүүлэлтийн дагуу улирал бүр үнэлж, холбогдох журмын хүрээнд үр дүнгийн урамшуулал олгох тогтолцоог тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн удирдлагын багийн хурлаар I улирлын албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хэлэлцэн баталж, үр дүнгийн урамшуулал олгосон. Нийт 28 албан хаагчид 16,521,660 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

3.23	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр төрлийг нэмэгдүүлэх, аюулгүй ажиллагааг хангах, баталгаажуулалт, засвар, үйлчилгээнд хяналт тавих	Нэмэгдсэн тоног төхөөрөмжийн тоо	3	4	100%	Эмнэлгийн тоног төхөөрөмжийг жил бүр стандарт хэмжил зүйгээр баталгаажуулдаг. Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны заавар, техник ашиглалтын паспорт, цаг ашиглалтын бүртгэлтийг аппарат тус бүр байршуулан тогтмол тэмдэглэл хөтлөн бүртгэдэг. 2026 оны 05 сард хяналт үнэлгээ, аюулгүй байдлын тойрон үзлэг хийж, Гэрээт ЭТТ-н инженер Г.Мөнхтулга 2026 оны 05 сарын 12 нд Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, баталгаажуулалт, засвар, үйлчилгээ хийж техник ашиглалтын цаг бүртгээгүй техник ашиглалтын паспорт дууссан 1 ажиллагаагүй тоног төхөөрөмж 1/цахилгаан эмчилгээний улаан гэрэл/ байсныг илрүүлж, холбогдох ажилтнаар зөрчлийг арилгууллаа. Төвийн хэмжээнд нийт 37 аппарат тоног төхөөрөмж байна.
		Хяналтын үнэлгээ хийсэн тоо	1	1		
4.1	Төвийн барилга, байгууламжын өрөө тасалгаанд шаардлагатай засварын ажлыг зохион байгуулах	Засвар, үйлчилгээний тоо	-	2	100%	Төвийн барилга, байгууламжийн өрөө тасалгаанд шаардлагатай засвар үйлчилгээний ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, чанартай гүйцэтгэн ашиглалтын аюулгүй байдал, ажиллах орчны нөхцөлийг сайжруулсан. Мөн өвөлжилтийн бэлэн байдалтай холбоотой барилгын дээврийн засварын ажил хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна.
4.2	Төвд шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах	Нийлүүлэх тоног төхөөрөмж, нэр төрөл, тоо ширхэг	2	Тухай бүрд	100%	Тус төвд шаардлагатай 1 тоног төхөөрөмжийн захиалгыг 29 тоот албан бичгээр НЭМГ-т хүргүүлсэн.
4.3	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах АЗ сертификатын суурь мэдлэг	АЗ сертификат авсан хүний тоо	2	3	100%	Төвийн хэмжээнд АЗ сертификатын суурь мэдлэг олгох сургалтад 2 ажилтан сууж сертификат авсан.

	олгох сургалтад хамрагдан, гэрчилгээг авах.					
5.1	Эрүүл мэндийн салбарын нэгдсэн VPN сүлжээ шилэн кабельд холбогдох ажлыг сайжруулах	сүлжээнд холбогдсон кабинет, өрөө	11 өрөө	3 өрөө нэмэх	100%	Төвийн хэмжээнд нэмэлтээр В1 давхарт 1ш, нэгдүгээр давхарт 2ш, хоёрдугаар давхарт 1ш өндөр хурдны wi-fi интернет төхөөрөмж 4-г шинээр холбож 2025 онд байрлуулсан, одоо 22 компьютер ажиллагаа хэвийн ашиглаж байна.
5.2	Төвийн хамтран ажиллах гадаад дотоодын ТББ болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах	Хамтын ажиллагааны тоо	2	4	100%	2026 оны 3 сард SUVD ART байгууллагатай хамтран төвийн үүдний хэсгийн тохижилтийг хийж гүйцэтгэсэн. - Kids all хүүхдийн тавилгын дэлгүүртэй хамтран хүүхэд хөгжлийн өрөөнд хүүхдийн номын буланг тохижуулж хүүхэд болон асран хамгаалагч нарын чөлөөт цагаа зөв өнгөрөөх, ном унших эерэг дадлыг дэмжих үйл ажиллагаа хийсэн. - Barlo world ХХК-тай “Хүүхдийн тайвшруулах гэрэл эмчилгээний өрөө”-г тохижуулах ажлын хүрээнд Хөрөнгө оруулалт хийх гэрээ хийгдсэн. Энэхүү ажлын хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авалт, засварын ажил хийгдэж байна. - Монголын Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хүүхэд асран хамгаалагч нарыг дэмжих төвд шаардлагатай ахуйн хэрэглээний болон эмчилгээнд хэрэглэх хэрэглэгдэхүүнийг хүлээн авсан.. - Монголын Аутизмын холбоотой хамтран 2026 онд төвийн хэмжээнд болон арга хэмжээний хүрээнд 2 ажил зохион байгуулан хэрэгжүүлсэн. Үүнд: - Монголын Аутизмын холбооноос 2 дах жилдээ зохион байгуулж буй “autism awareness day 2026” мэдээллийн яармагт 04 сарын 02-ны өдөр Төвийн үйл ажиллагааг олон нийтэд танилцуулж мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгсөн

						- 04 сарын 07-нд төвийн ажилтан болон асран хамгаалагч 57 хүнд аутизмтай хүүхдийн сөрөг зан үйлийг зохицуулах тухай сургалт зохион байгуулсан.
6.1	Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлэх	Биелэлтийн хувь	-	50%	100%	ISO 9001 хэрэгжүүлэх зорилгоор 2025-2028 оны байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгасан.
6.2	Төвийн үйл ажиллагаатай холбоотой тушаал шийдвэрийг боловсруулж мөрдөж ажиллах	Тушаал шийдвэрийн тоо	-	Тухай бүрд	100%	2026 оны хагас жилийн байдлаар төвийн үйл ажиллагаатай холбоотой 29 “А” тушаал, 41 “Б” тушаал шийдвэрийг боловсруулж мөрдөж ажилласан байна.
6.3	Байгууллагын статистик, тоон мэдээллийг сайжруулах, дотоод хяналт, үнэлгээг хэрэгжүүлэх	Үнэлгээний тайлан, зөвлөмж, хэрэгжилтийн хувь	-	50%	100%	Хүүхдийн сэргээн засах Хантуул төвийн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтийг төвийн даргын 2023 оны А/58, чанарын шалгуур үзүүлэлтийг бодох аргачлалыг боловсруулан 2026 оны А/14 тушаалаар батлуулсан. Тусламж үйлчилгээний төрөл бүрийг хамруулан нийт 22 үзүүлэлтээр, үүнээс өвөрмөц 3 шалгуур үзүүлэлтийг гаргасан. Чанарын багийн дотоод хяналтыг 12 чиглэлээр хяналт хийх үйл ажиллагааг гарган ЭТҮХОД-оор батлуулсан. Үүнд: · 2026 оны 03-р сард эмч сувилагч нарт хийт 2 удаагийн ижил мэргэжилтэний үнэлгээг хийсэн. Өвчний түүх хөтлөлт 90 % . · 2026 онд Эмчилгээ оношилгооны чиглэлээр 3 хяналтын хуудас шинэчлэн боловсруулсан. · Сувилагч, нарын сувилгааны түүх, анхан шатны маягт хөтлөлтөнд ижил мэргэжилтэний үнэлгээг нийт удаа 26 картанд хийхэд хөтлөлт 83 % байна. · Өвөрмөц 3 шалгуур үзүүлэлтэд үнэлгээг хийхэд 91% байна.

6.4	Байгууллагын дотоод, гадаад оролцогч талуудын хэлэлцүүлгийг зохион байгуулах	Хэлэлцүүлгийн тоо	-	2	100%	2026 оны 03 сарын 25-ны өдөр Нийслэлийн Хүүхдийн Сэргээн Засах "Бяцхан тэмүүлэл" төвийн зохион байгуулсан "СЭРГЭЭН ЗАСАХ ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ЭМНЭЛГИЙН ЭМЧ, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ДУНД КЕЙС ХЭЛЭЛЦҮҮЛЭГ"-т амжилттай оролцсон.
6.5	Тусламж үйлчилгээний үзлэгийн мэдээллийг цахим системд шилжүүлэх	Хэрэгжилтийн хувь	-	50%	100%	Тусламж, үйлчилгээний үзлэгийн мэдээллийг карте цахим системд шилжүүлэн үзлэгийн цаг, өдрийн эмчилгээний цагуудыг цахимаар олгож, ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, бүртгэл мэдээллийн чанар, хүртээмж, тайлагналтын үр нөлөөг сайжруулсан бөгөөд цаашид цахим бүртгэлийг тогтвортой ашиглах нөхцөлөөр ханган ажиллаж байна.
Хэрэгжилтийн хувь %					93,6%	